

ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТАНД ФИЛОСОФИ АРГА ЗҮЙГ УДИРДЛАГА БОЛГОХ НЬ

С.Хишигтогтох (ХИС, НХУС-ийн багш)

МУИС, НШУС

Философийн Тэнхмийн докторант

E-mail: Itsumo_hanaa@yahoo.com

Тухайр үгс: сургалт, сургалтын шинэчлэл, сэтгэн бодохуй ба эргэцүүлэл, хэрэгцээ, сонирхол, ярилцлага

Гал утга: “Өнөө үед дэлхий дахинаа боловсрол нь хүн төвтэй болж¹ байгаа бөгөөд хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлогийг харгалзан хувийн сонирхолыг сэдэлжүүлэлт дээр суурилсан мэдлэгийг олгох, бүтээх тийм сургалтыг шаардаж, ихэнх улс оронд энэхүү сургалтын зарчмууд бодитойгоор хэрэгжиж байгаа тухай эх сурвалжуудад тусгагджээ. Суралцагчдад бэлэн мэдээлэл дамжуулдаг тогтолцооноос татгалзаж, бие даасан сэтгэн бодохуй, эргэцүүлэл, ёс суртахууны төлөвшилийг хангах зорилгоор нээлттэй, олон хувилбар бүхий сургалтын философи арга зүйг боловсрол судлаачид, философичид дэвшүүлж, тэдгээрийн ач холбогдлыг синтезлэн сургалтанд ашиглах асуудал эдүгээ чухлаар тавигдаж байна.

Энэ өгүүлэлд нийгмийн хөгжилд боловсролын гүйцэтгэх үүрэг, нийгмийн болон хувь хүний хэрэгцээ сонирхолд чиглэсэн хөгжүүлэх сургалтанд философи арга зүйн гүйцэтгэх үүрэг, боловсрол сургалтын арга зүйн тухай философи баримтлалууд зэргийг авч үзлээ.

Боловсрол тасралтгүй үргэлжлэх ба шинэчлэгдэх процесс болох нь:

Орчин үеийн боловсролын философийн эцэг гэгдэх Ж.Дьюи “Ардчлал ба боловсрол” зохиолын эхний хэсэгт өгүүлэхдээ: “Аливаа амьд биет ба амьгүй зүйлсийн хооронд хамгийн том ялгаа бол амьд биет үргэлж шинэчлэгдэж байдаг оршино. ...аливаа амьд биет амьд байгаа л бол эргэн тойрны энергийг өөртөө ашиглахыг зорьдог., гаднын хүчний энергийг өөртөө ашигтайгаар ашиглаж, хариу үйлдэл үзүүлж чадахгүй бол өөрийн амьд биет гэсэн утгаа алддаг. Жишээ нь, ургамал ургахдаа гэрэл, ус, чийгийг өөртөө ашиглаж, өөрийн амьд чанараа хадгалан үлдэхэд хэрэглэдэг... Амьдрал бол хүрээлэн буй орчинд нөлөөлөх замаар өөрийгөө шинэчлэх үйл явц билээ.”² гэжээ.

Ийнхүү амьд бүхэн орчинтойгоо бодисын солилцоо явуулж, оршин тогтнохуйгаа хангах, ашигтай энергийг өөртөө шингээж, хэрэггүй зүйлээ гадагшлуулж байдаг байгалийн хуулийн үйлчлэл дор оршдог аж. Түүнчлэн биологийн амьд организм хувьсан өөрчлөгдөхийн зэрэгцээ шинэ, шинэ энергиэр нөхөн сэргээгдэж байдагтай төсөөтэй өөрчлөгдөн шинэчлэгдэх хууль нийгэмд ч мөн үйлчилж байдаг тухай социологийн сонгодогууд (О.Конт, Г.Спенсер)-ын бүтээлд тусгагдсан нь бий.

Нийгмийн хөгжлийн урагшлах үйл явц чухамдаа боловсролын шинэчлэлийн ашигтай солилцооноос их хамаарах юм. Өөрөөр хэлбэл, орчноосоо (хөгжингүй улс орнуудын сургалтын жишиг) өөртөө ашигтай боловсролын үзэл санаа чиг хандлага, арга зүйг өөрийн орны сэтгэлгээний онцлогт буулгах замаар сургалтанд нэвтрүүлэх нь манай орны боловсролын тогтолцооны урагшлах үйл явцад чухал ач холбогдолтой. Үүний зэрэгцээ өнгөрсөнд үүргээ

1. Ичинхорлоо.Ш, Боловсролын философи үзэл, санаа: эрт ба эдүгээ. УБ., 2011. 6 дахь тал

2. Нэмэхжаргал. Т Боловсролын философийн үзэл баримтлал-арга зүйн асуудал. УБ., 2009. 4 дэх тал

гүйцэтгээд, одоо хэрэгцээ шаардлага нь буурсан үзэл хандлагаас төрөлхтөнд үр ашгаа өгсөөр байх уламжлалыг хадгалах замаар боловсролын шинэ чиг хандлага, шинэ философиор сэлбэгдэх нь эдүгээ нийгмийн хөгжлийн шаардлага боллоо.

Боловсролын тухай Ж.Дьюнгийн философид өгүүлснээр, “Нийгмийн амьдралын аливаа бүлэг шинэчлэгдсэн ч тэдний олж авсан туршлага нь үргэлжлэгдэн хадгалагддаг нь бодит зүйл юм. Тэгэхээр боловсролыг амьдралын нийгмийн талын үргэлжлэл гэж хэлж болно... Аливаа нийгмийн анги давхаргад багтан орсон ямар ч хүн эхээ төрөхдөө ямар ч хэл яриа мэдэхгүй, нийгмийн үзэл бодолгүй, сул дорой амьтан байдаг. Нийгмийн аливаа анги давхрагын хүн цаг нь ирэхэд үгүй болох нь гарцаагүй. Гэлээ ч энэ тухайн бүлгийн амьдрал үргэлжлэхэд саад болохгүй... гэхдээ үхэж, төрөх нь боловсролыг зайлшгүй хэрэгцээтэй болгодог³ гэжээ. Нэг талаас аль ч нийгэмд саяхан төрсөн гишүүд, нөгөө талаас, нэгэнт хэрэгтэй туршлага мэдлэгийг эзэмшсэн гишүүдийн хоорондох залгамж холбоо нь боловсрол юм. Ингэж чадахгүй бол тухайн нийгмийн амьдрал төгсгөл болно.

Нийгэм нь биологийн амьдралын нэгэн адил холбоо харилцаанд тулгуурлан оршдог. Энэ харилцаа холбооны ачаар хүмүүсийн бүхий л оршин тогтнохуйн чухал нандин зүйлс боловсрол, туршлагаар дамжин насанд хүрэгчдээ залуу үед хүрдэг. Ийм залгамж холбоогүйгээр ямарч нийгэм оршин тогтнохгүйн зэрэгцээ мөн өөрийгөө шинэчлэн цаг үеийн хөгжилтэй зэрэгцсэн шинэ үзэл санаа, шинэ технологи, арга зүйгээр боловсролын чиг хандлагыг сэлбэхгүйгээр нийгэм, хүн ард гаднын хүчин зүйлд залгиулна, эс бөгөөс мөхөж ч болно. Өөрөөр хэлбэл, боловсрол нь өмнөх үеийн ашиг тустай мэдлэгийг уламжлахын зэрэгцээ нийгмийн хөгжлийг мэдэрч шинэчлэгдэх замаар хөгжих үйл явц юм. Боловсролын байгууллага нийгэмдээ ямар боловсролтой иргэн бэлтгэн нийлүүлж буй нь тухайн улс орны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох хүчин зүйлийн нэг юм.

Сэтгэн бодохуйг хөгжүүлэхэд тулгуурласан сургалтын философи арга зүйн тухайд:

Нийгэм-улс төрийн болон эдийн засгийн шинэчлэлтэй холбогдон боловсролын тогтолцоо сургалтын шинэ зарчмаар сэлбэгдэх хэрэгцээ аяндаа бий болсон билээ. “Сургалтын үйл ажиллагаа уламжлалт нийгмүүдийн нөхцөлд суралцагчдад бэлэн мэдлэгийг дамжуулан эзэмшүүлэх гол зориулалттай байсан бол эдүгээ үед тэр нь суралцагчдад шинийг хайж түүнээ олох, асуудал дэвшүүлээд, түүнээ шийдвэрлэх арга барил эзэмшүүлэх чухал зориулалттай болжээ. Боловсролын болон сургалтын үйл ажиллагааны энэхүү хэрэгцээ шаардлагыг хангах зорилго бүхий философичид, боловсролын онолчид сургалтын үр дүнтэй арга хэрэгслийг эрж хайсаар ХХ зууны дунд үеэс боловсролын шинэ парадигм, шинэ үзэл санааг эрчимтэй дэвшүүлсэн.

Боловсролын хуучин загвараас татгалзаж, сургалтыг сэтгэн бодохуй, сэтгэхүйн соёлын чиг хандлагатай болгох талаар “Хүүхдэд зориулсан философи” хэмээх олон улсын хөтөлбөр улс орнуудад хэрэгжиж эхэлсэн. Хүүхэд зориулсан философи хөтөлбөрийг зохиогч М.Липман дунд сургуулийн үйл ажиллагаатай танилцсаныхаа үндсэн дээр боловсруулсан бөгөөд тэрээр “Энэхүү хөтөлбөрт Сократын сургалтын аргад илэрдэг сурган хүмүүжүүлэх зарчмуудыг сэргээж байгаа гэж хэлж болно.⁴ гэжээ.

Сократ харилцан яриа хамтран хэлэлцэх, эргэцүүлэх, төвөгтэй асуудлыг хүмүүс өөр өөрсдийн байр сууринаас нотлох, маргах замаар үнэн зөв дүгнэлтэнд хүрэх ярилцлагын аргыг сургалтын шалгарсан арга гэж үзэж байв.

Харин “М.Липман сурах бичгээс, хүүхдийн үгийн санг ашиглаад хэлэлцэж болохуйц, хүртээлтэй, ойлгомжтой, сонирхолтой, бас өдсөн шинжтэй өөр текет хэрэгтэй... өгүүллэгүүдийн агуулга нь анги бүлгийн насны онцлогоос шалтгаалж хүнд хөнгөн янз бүр байна... өгүүллэгийг

3. Нэмэхжаргал.Т Боловсролын философийн үзэл баримтлал,арга зүйн асуудал. УБ., 2009. 5 дахь тал

4. Хүүхдэд зориулсан философи. (Орч.Отгонбаяр.Ж, Нэмэхжаргал.Т) УБ., 2005. 27 дахь тал

бичихдээ голлон анхаарсан зүйл бол ... хүүхдэд ойлгомжтой ойр дөт уран сайхны дэвсгэр бий болгож түүгээрээ дамжуулан философийн асуудлыг тодорхой эрэмбэ дараатай шигтгэж өгөх явдал⁵ гэж үзсэн. Эндээс үзэхэд, хүүхдэд тухайн зүйлийг цээжлүүлэхээсээ өмнө ойлгуулах, анхаарал сонирхол, сэдлийг нь төрүүлэх, хүүхэд тухайн зүйлд өөрөө дуртай болох, өөрийн эргэцүүлэл дээр дүгнэлт гаргах, бусадтай чөлөөтэй ярилцах замаар Сократын диалог сургалтын арга зүйг сургалтанд нэвтрүүлэхийг чухалчилсан байдаг. Тухайлбал, “Бага насны хүүхдэд зориулсан өгүүллэгт яагаад амьтдын хүрээлэнд байгаа туулайг буудаж болдоггүй вэ?, ойд байгааг нь буудаж болдог вэ?, гэрийн амьтанг зовоож болохгүй гэдэг хэрнээ яагаад тахиа, үхэр гэх мэт амьтдын махыг идэж болдог вэ? гэх мэт асуудлаар эргэцүүлэл хийдэг⁶ гээд, хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлолт тохирсон олон сонирхолтой бөгөөд эргэлзээтэй, асуудал дэвшүүлсэн өгүүллэгийг энэ хөтөлбөртөө ашигласан байдаг.

Асуудлыг янз бүрийн нөхцөлд өөрчлөн энгийнээс нарийн руу чиглэсэн шинэ хөгжүүлэх сургалтын аргуудыг сургалтанд ашиглахаар хөтөлбөрийг боловсруулсан нь хүүхдийн сонирхол сэдлийг төрүүлэх замаар сэтгэн бодох бүтээлч ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн энгийн хэрнээ философи агуулгатай, суралцагчдын сурах үйлд ихээхэн ач холбогдолтой гэж судлаачид дүгнэж байна.

Энэхүү суралцагч төвтэй сургалтын арга, арга зүйг монгол хүүхдийн сэтгэлгээнд буулгах замаар бид түүх, нийгэм, уран зохиол зэрэг хүмүүншүүлэх, нийгэмшүүлэхэд чиглэгдсэн хичээлүүдээр сургалтанд нэвтрүүлж чадвал бидний сургалт зохих хэмжээнд суралцагчдын хэрэгцээ сонирхолд тулгуурласан идэвхижүүлэх сургалт руу чиглэхийн зэрэгцээ суралцагчдад ч ач холбогдлоо өгөх талтай.

Насны онцлогоос шалтгаалж асуудлын агуулга нь өргөсөхийн зэрэгцээ шийдвэрлэх асуудал хүндэвтэр болох тухай, хүүхдийн сонирхол хэрэгцээг харгалзах, бодит амьдралын нөхцөлтэй асуудлыг уялдуулах тухай хүүхдэд зориулсан философи хөтөлбөрийг зохиогчдын санаа бусад боловсролын философичдын үзэл санаанд ч тусгагдсан нь бий.

Мөн Томмазо Кампанелла хүмүүжил боловсролын тухай өгүүлэхдээ: “Хүүхдийг 7 нас хүрэхэд гуталчин, талхчин, дархан, мужаан, зураачын урлангуудаар явуулж хүүхэд бүрийн сонирхол авьяасыг тодруулдаг. Анги ахих тусам математикийн болон байгаль шинжлэлийн, дараа нь анагаах зэрэг бусад нарийн шинжлэх ухааныг судлуулж хэлэлцэн маргалддаг. Эцэст нь хүүхдүүд аль шинжлэх ухаанд их ололт амжилт гаргах салбараа авьяас сонирхолынхоо дагуу сонгон суралцдаг⁷ тухай өгүүлжээ.

М.Монтень “Хүүхэд өөрийхөө сонирхол чадавхиа чөлөөтэй илрүүлэх боломж өгч, янз бүрийн зүйлийн амтыг өөрөө үзэх, замаа өөрөө олж авахад нь туслах хэрэгтэй... Багш сурагчийнхаа цээжилсэн зүйлийг шалгахын оронд тэр үзсэн зүйлийнхээ утгыг ойлгосон, тухайн мэдлэг түүний амьдралд ямар ашигтай тухай асууж яриулах хэрэгтэй гэж сургаж, хүүхдийн сониуч занг хөгжүүлэхийн ач холбогдлыг тайлбарласан⁸ буй.

Чехийн нэрт сурган хүмүүжүүлэгч Я.А.Коменский “Хүүхдийн насанд тохирохгүй тийм зүйл өгөхгүй, хэрэглэхгүй байх, хүүхэд сурах дур хүслийг байж болох бүх аргаар асаах хэрэгтэй... Аливаа зүйлийн учрыг хүүхэд өөрөө олж сурах⁹ гэх зэргээр багшийн сэдэлжүүлэх үйл, сурагчын бие даан боловсрох, хамгийн гол нь мэдлэг эзэмшихээс гадна чадварт суралцах үйлийг онцолж байв.

Америкийн сурган хүмүүжүүлэгч, прагматист Ж.Дьюи өнөөгийн боловсролын философийг үндэслэгчийн нэг юм. Тэрээр хувь хүний давтагдашгүй шинж нь тухайн хувь хүний сургах үйл ажиллагаанд ихээхэн нөлөөлдөг болохыг онцолсон байдаг. “Хүн бүр өөрийн

5. Хүүхдэд зориулсан философи. (Орч.Отгонбаяр.Ж, Нэмэхжаргал.Т) УБ., 2005. 34 дэх тал

6. Мөн тэнд. 35 дахь тал

7. Ичинхорлоо.Ш. Боловсролын философи үзэл, санаа: эрт ба эдүгээ. УБ., 2011. 26 дахь тал

8. Мөн тэнд. 28 дахь тал

9. Мөн тэнд.

бодит бололцоо, шинж байдлаараа бусдаас өчүүхэн төдий ч атугай ялгаатай... эдгээр ялгаа нь хүний авьяас чадварт нөлөөлж байдаг бөгөөд хичээлийн тоо, хэмжээ хичээн их байсан ч энэ ялгааг арилгаж чадахгүй¹⁰ гэжээ. Эндээс хүний төрөлхийн мөн чанар нь түүний гадаад хэрэгцээ сонирхолд ихээхэн нөлөөлдөг бөгөөд энэхүү дотоод түлхэц, хүсэл гэмүүллийг харгалзахгүйгээр суралцагч бүрт нэгэн хэмээр хандах (эдүгээ манай ихэнх сургалтанд ажиглагддаг) нь алдаатай гэсэн санааг гаргаж ирсэн. Тэрээр "Сургалтанд үйлчилж буй нийтлэг адил тэгш арга хэрэгслүүдээс нэг төрлийн үр дүн гарах бололцоогүй гэсэн дүгнэлт гарах бөгөөд иймээс бид аргуудаа хүн бүрийн онцлогт тохирохуйц олон хувилбартай болгож боловсруулахыг эрмэлзэж байгаа билээ¹¹ гэжээ. Ж.Дьюн дээрх арга зүйг ямар нэг хэмжээгээр сургалтанд хэрэгжүүлж чадвал гарцаагүй үр дүнгээ өгөх бөгөөд хүүхдийн хэрэгцээ сонирхол, хувийн онцлогийг харгалзсан сургалт нь тэдэнд ихээхэн туршлагыг хуримтлуулдаг тухай өгүүлсэн буй.

Тэрээр хүний амьдрах чадвар гадны нөлөөгөөр бий болдоггүй, харин асуудлыг шийдвэрлэх өөрийн арга барилтай болсноор бий болдог. Хэрвээ бид ямар нэг бэрхшээлийг даван туулж чадна гэж байгаа бол бид зөвхөн мэдлэгтэй байгаад зогсохгүй асуудлыг шийдэх өөрийн гэсэн арга барилаа олж хэрэглэнэ гэсэн үг гэж үзсэн нь зөвхөн мэдлэгтэй байх, мэдлэг байх чухал биш, мэдлэгийг ашиглаж чаддаг чадвар болгох нь чухал гэсэн санааг дэвшүүлсэн байна.

Сургалт, мэдлэг боловсрол, чадварын талаарх Ж.Дьюнигийн энэ санаа орчин үеийн сургалтанд ихээхэн чухлаар тавигдаж байгаа билээ. "Уламжлалт нийгэмд сургалт үндсэндээ нэг талтай, өөрөөр хэлбэл, багш бүхнийг дамжуулагч, чиглүүлэгч байсан бол эдүгээгийн сургалт багш, суралцагч гэсэн хоёр талтай болж, тэдний хооронд хамтын ажиллагаа гарцаагүй тогтдог болсон¹²-оор багш идэвхтэй дамжуулагч, суралцагч хуулбарлан хүлээн авагч биш, тэд хамтдаа мэдлэг бүтээгч байдлаар ажиллах сургалтын зарчмын тухай их ярьж байна. Хэдийгээр бэрхшээлтэй ч зарим улс оронд дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлээд нэлээд хугацаа өнгөрч үр дүнг нь сургалтандаа нэвтрүүлж байгааг бид олон эх сурвалжаас харж болно.

Манай орны хувьд эдийн засаг, нийгмийн сэтгэлгээ нь ихээхэн өөрчлөгдөөд байгаа хэдий ч өнөөгийн сургалтын явцыг дотроос нь ажиглахад сургалтын шинэчлэлд нийцүүлэх алхам доривтой хийгдэхгүй, сургалтын аль ч салбарт уламжлал шинэчлэлийн завсарын байдалтай байна. Нэг талаас шавь төвтэй сургалт голлох болсон нь багш суралцагчыг шахаж шаардах үйлийг урсгалаар орхисон, хүүхдийн бие даан эрэл хайгуул хийх сэдэлжүүлэх арга зүй дутмаг, суралцагчдын дунд нийтлэг ажиглагдах нь сурах үйлд хойрго, идэвх сонирхолгүй, бие даах чадвар сул зэргээс шалтгаалан сургалтын арга зүйн дотоод зөрчлийг үүсгэж чанарыг бууруулах нэг шалтгаан болох талтай.

Идэвхжүүлэх сургалтын шинэ арга зүйг ашиглах тухай бүх боловсролын салбарт яригдаж, энэ талаарх бүтээл, ном, гарын авлагыг эрдэмтэн судлаачид олны хүртээл болгож байна. Гэвч манай орны хувьд сургалтын хөгжүүлэх, идэвхижүүлэх арга зүйн асуудал сургалтанд үзэгдэхүйц хэрэгжих нь хараахан дутмаг байгаа нь энэ талаар илүү доривтой алхам хийх асуудал багш, сурган хүмүүжүүлэгчдийн өмнө тавигдсаар байна.

Эцэст нь дүгнэхэд, нийгмийн хөгжлийн хурд, хэрэгцээ шаардлагыг хангасан, амьдрах чадвартай боловсролтой, хүмүүнлэг иргэн бэлтгэн нийлүүлэх нь боловсролын байгууллагын эрхэм зорилго байдаг. XXI зууны нийгмийн чиг хандлага хүний эрх ашиг, хэрэгцээ сонирхолд нийцсэн, хүн нийгэмд хэрэгтэй боловсрол олгох сургалт руу боловсролын тогтолцоог хөтөлж байгаа тухай олон эрдэмтэн судлаачид ярьж байна. Эрин зууны хэрэгцээ шаардлагыг мэдэрч манай оронд хөгжингүй улс орнуудын боловсролын тогтолцоо суралцагч төвтэй сургалтын зарчмыг хэрэгжүүлж байна.

Манай улс хөгжүүлэх сургалтын зарчмыг амьдралд хэрэгжүүлж хэвшихийн тулд

10. *Нэмэхжаргал.Т. Боловсролын философиин үзэл баримтлал-арга зүйн асуудал. УБ.,2009. 15 дахь тал*

11. *Нэмэхжаргал.Т. Боловсролын философиин үзэл баримтлал-арга зүйн асуудал. УБ.,2009. 15 дахь тал*

12. *Хүүхдэд зориулсан философи. (Орч. Отгонбаяр. Ж. Нэмэхжаргал.Т) УБ., 2005.*

багш мэргэжлээр бэлтгэгдэж байгаа боловсон хүчинд онолын мэдлэг болон шинэ дидактик чадварыг шаардлагын түвшинд эзэмшүүлэх нь асуудлын эхний алхам юм. Тухайлбал, онолын мэдлэгийг хэрхэн практикт ашиглах, сурагчдийн хэрэгцээ сонирхлыг хэрхэн нээж сэдэлжүүлэх, хөгжүүлэх, түүний урьдач нөхцлийг хэрхэн бүрдүүлэх, сургалтын үр ашгийг хэрхэн үнэлж, сайжруулах гэх зэрэг асуудалд багш эхлээд суралцах, тэрхүү чадварыг эзэмших, эзэмшүүлэх эдгээр асуудал өнөөгийн түвшинд учир дутагдалтай бэлтгэгддэг. Энэ дутагдал нь багшийн заах арга зүйн үнэлэмжийг бууруулж, сурагчдийг хичээлдээ сонирхол, идэвх, санаачлагагүй байдалд хүргэх талтай. Тиймээс багш мэргэжлээр бэлтгэгдэж байгаа боловсон хүчин онолын мэдлэгийн зэрэгцээ, дидактик чадварыг практик түвшинд сайтар эзэмших, энэ чиглэлээрх сургалт прагматик агуулгаар явагдах шаарлагатай юм. Үүнийг хэрхэн эзэмшсэнээс шинэ сурган хүмүүжүүлэгчдээр дамжин дараагийн сургалтанд иргэнийг хөгжүүлэх сургалтын зарчим хэрхэн хэрэгжих, түүний үр дүн нь ямар байх асуудал шалтгаална.

НОМ ЗҮЙ

Ичинхорлоо.Ш, Боловсролын философи үзэл, санаа: эрт ба эдүгээ. УБ., 2011

Нэмэхжаргал. Т Боловсролын философийн үзэл баримтлал-арга зүйн асуудал. УБ., 2009

Хүүхдэд зориулсан философи. (Орч.Отгонбаяр.Ж, Нэмэхжаргал.Т) УБ., 2005

ABSTRACT

This article considered summary that a role which education execute in the social development, a problem to be leadership philosophy method in education to develop making toward in demand and interest of society and individual, the problem about opportunity to put into practice training principle in education of our country.